



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Жавхлан Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Ж.Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн


З.Нарантуяа Улсын Их Хурлын гишүүн

М.Оюунчимэг Улсын Их Хурлын гишүүн

Б.Ундармаа Улсын Их Хурлын гишүүн

2. Ажлын хэсэгт мэргэжлийн туслалцаа авах чиглэлээр мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Жавхлан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Д.ТЭРБИШДАГВА